



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/08

Номгон

Г Хөдөө аж ахуйн кластер төслийн багц Г
ажлуудад 2025 онд батлагдсан төсөвт өртгийг
хуваарилан зарцуулах тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус тус заасан "Тогтвортой хөдөө аж ахуй" зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVI. 1.9, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай" А-33 дугаартай тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12 дугаарт батлагдсан 12 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хавсралтаар баталсан ингэний сүүний үйлдвэр, 1000 тн хүчин чадалтай мах, ногооны зоорь байгуулах ажлуудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.


2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XIX.1.14 дугаарт батлагдсан "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах" төслийн энэ онд батлагдсан 1,824.6 сая төгрөгийг энэхүү захирамжийн хавсралтын дагуу хуваариар баталж төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах" төслийн батлагдсан

625010013

ажлуудыг зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр
сарын 10-ны өдрийн 4108 дугаар
захирамжийн хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕР
БАЙГУУЛАХ ЖАГСААЛТ**

Багц	Төслийн нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Гэрээний дүн	Авсан санхүүжилт	2025 онд санхүүжих дүн
1	2	3	4	5	6	7
1	Ингэний сүүний үйлдвэр	2022	2025	4,853.75	3,848.14	1,005.61
2	Мах ногооны зоорь	2022	2025	4,869.19	4,074.94	794.25
НИЙТ				9,772.94	7,923.08	1,799.86

-----oOo-----